

МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ-385, ҮНДСЭН ХУУЛЬ-100, УЛААНБААТАР ХОТ-100 ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТАЙЛАН

2024 оны 11 дүгээр сарын 27

Улаанбаатар хот

Монгол Улсын нийслэл үүсэн байгуулагдсаны 385 жил, Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, Анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жил, Нийслэл Хүрээг “Улаанбаатар хот” хэмээн нэрийдсэний 100 жилийн ойд зориулсан үзэсгэлэнг нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Архивын газар, Улаанбаатар хотын музей хамтран Яармаг дахь Нийслэлийн төр захиргааны төв байрны “Б” блокт 2024 оны 11 дүгээр сарын 18-27-ны өдрүүдэд зохион байгууллаа.



2024.11.20-ны өдрийн үзэсгэлэнгийн нээлтэд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ү.Ганболд, Засаг даргын зөвлөх М.Найданхүү, Нийслэлийн Архивын газрын дарга Н.Туул, Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх, Байгаль орчны газрын дарга Р.Энхтайван, Улаанбаатар хотын музейн захирал П.Даваасүрэн болон бусад зочид, төлөөлөгчид оролцлоо.



Үзэсгэлэнг Яармаг дахь Нийслэлийн төр захиргааны төв байранд байрлах 23 байгууллагын 1200 гаруй албан хаагч, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, төр захиргааны байгууллагуудаар үйлчлүүлсэн 534 гаруй иргэд, ХУД-ийн 34 дүгээр сургуулийн 3^а бүлгийн 50 сурагч, шинэ монгол харүмафүжи сургуулийн 8 дугаар ангийн 30 сурагч зэрэг нийт 1800 гаруй албан хаагч, иргэд, хүүхэд багачуудад Анхдугаар Үндсэн хуулийн ач холбогдол, хууль ёсоо эрхэмлэн дээдлэх үзэл санааг олон нийтэд тайлбарлан таниулж үзэсгэлэнгийн талаар иргэдээс “Санал хүсэлт”-ийн дэвтэрт сэтгэгдэл бичүүлж ажиллаа.



Үзэсгэлэнд Өндөр гэгээн Занабазарын хөрөг зураг, ардын зураач Ү.Ядамсүрэнгийн “Анхны Өргөө”, “Хүрээний нүүдэл” уран зураг, хутагтын “Ривогэжайганданшаддувлин” хийдийн уран зураг, Их Хүрээг Сэлбийн хөвөөнд суурьшуулсан архивын баримт, 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хууль, Үндсэн хуулийг боловсруулах бэлтгэл ажлын тухай, хуулийн төслийг зохиох комиссыг томилсон тогтоол, Улсын Анхдугаар их хуралд нийслэл



хотоос сонгогдсон төлөөлөгчдийг батламжилсан тухай баримт бичгүүд, Нийслэл Хүрээг “Улаанбаатар” хэмээн нэрлэсэн тогтоол, хотын Засаг захиргаа, бүтэц, орон тоо, тамга, тэмдэг, нийслэлийн дэвсгэр нутаг зэргийг харуулсан 130 архивын баримт, эд өлгийн зүйл, гэрэл зургийг дэлгэн олон нийтэд сурталчилж ажиллаа.